



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар АНЧ

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Өвөрмодот 1 дүгээр багийн нутаг дэвсгэр "Их нөмөр" гэх газар нутаглаж байгаа малчин Мишигийн Дагвын хотонд хязгаарлалтын дэглэмийн хугацаанд галзуу өвчний шинж тэмдэг шинээр илрээгүй тул 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан нутаг дэвсгэрийн хил залгаа байгаа мал амьтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/06 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай

ДАРГА  Д.БАТБАЯР

622401027

D:Alban bichig;Zahiramj 2024